

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

195.	Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	858
196.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	860
197.	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	865
198.	Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	867

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

199.	Хуулийн төслүүдийг буцаах тухай	Дугаар 33	867
200.	Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 34	867

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

201.	Засгийн газарт чиглэл өгөх тухай	Дугаар 50	872
------	----------------------------------	-----------	-----

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

202.	Журам, чиглэл шинэчлэн батлах тухай	Дугаар 71	873
203.	Үндэсний хөтөлбөр батлах тухай	Дугаар 72	881
204.	Тооны дээд хязгаар, мөнгөн төлбөрийн хэмжээ тогтоох тухай	Дугаар 73	889
205.	Цагдаагийн албан хаагчид мөнгөн урамшил олгох журам батлах тухай	Дугаар 86	890

206.	Ардчилсан хувьсгалын 25 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай	Дугаар 92	893
207.	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 98	894
208.	Журамд нэмэлт оруулах тухай	Дугаар 103	985
209.	Дотоодын цэргийн ангиудыг татан буулгах тухай	Дугаар 108	896

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 04 дүгээр  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн байцаан шийтгэх хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

#### 1/15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг:

“15.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхээр хүлээн авсан шүүгч, шүүх бүрэлдэхүүн бусдаас нөлөөлөл үзүүлэхээр завдсан тохиолдолд нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.”

#### 2/45 дугаар зүйлийн 45.3.4 дэх заалт:

“45.3.4. Үүргээ гүйцэтгэх замаар уг хэргийн байдлыг мэдэх болсон эвлэрүүлэн зуучлагч.”

#### 3/49 дүгээр зүйлийн 49.1.5 дахь заалт:

“49.1.5. ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал байгаа бол.”



**4/220<sup>1</sup> дүгээр зүйл:**

**“220<sup>1</sup> дүгээр зүйл.Анхан шатны шүүхэд ирсэн хэргийг хуваирах”**

220<sup>1</sup>.1.Анхан шатны шүүхэд ирсэн хэргийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон хэрэг хуваиралах журмын дагуу хуваарилна.”

**5/253 дугаар зүйлийн 253.10 дахь хэсэг:**

“253.10.Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шүүх хуралдааны явцыг дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулна.”

**6/343 дугаар зүйлийн 343.3 дахь хэсэг:**

“343.3.Хяналтын шатны шүүхэд ирсэн хэргийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон хэрэг хуваиралах журмын дагуу хуваарилна.”

**2 дугаар зүйл.**Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дахь хэсэгт “Анхан шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны мэтгэлцэх зарчмыг хангахдаа шүүх хуралдаанд талууд, тэдгээрийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч болон улсын яллагчид асуулт асуух, хариулах, нотлох баримтыг танилцуулах, өөрсдийн тайлбар өгөх, үндэслэлээ хамгаалах, угүйсгэх боломжийг тэшг олгоно.” гэсэн хоёр дахь өгүүлбэр, 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийн “шийдвэрлэхэд 3” гэсний дараа “хүртэл” гэж, 347 дугаар зүйлийн 347.1 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүхийн тогтоолд үг, үсэг, тооны зэрэг техникийн шинжтэй алдаа гарсан бол танхимын шүүх бүрэлдэхүүн хуралдаж, залруулга хийж болно.” гэсэн хоёр дахь өгүүлбэр тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 32 дугаар зүйлийн 32.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“32.6.Эрүүгийн хэргийг анхан, давж заалдах болон хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоосон шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг үндэслэн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгч, танхимын тэргүүн захирамж гарган томилно.”

**4 дүгээр зүйл.**Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 289 дүгээр зүйлийн 289.2 дахь хэсгийн “хэрэгт” гэснийг “шүүхийн шийдвэрт” гэж,

310 дугаар зүйлийн 310.1 дэх хэсгийн “аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч хүлээн авч, хэргийг хуваарилна.” гэснийг “тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон хэрэг хуваарилах журмын дагуу хуваарилна.” гэж, 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсгийн “улсын яллагч, эсхүл дээд шатны прокурор” гэснийг “Улсын ерөнхий прокурор” гэж, 346 дугаар зүйлийн 346.1 дэх хэсгийн “шүүх бүрэлдэхүүнийг томилно.” гэснийг “шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоосон шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг үндэслэн томилно.” гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 04 дүгээр  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

#### 1/5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэг:

“5.6. Тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээдээс нөлөөлөхөөр оролдсон тохиолдолд нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.”

#### 2/13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэг:

“13.5. Талууд байгуулсан гэрээндээ маргаан гарвал эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлүүлэхээр тохиролцсоныг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журам тогтоосон гэж үзнэ.”

#### 3/25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалт:

“25.1.7. нэхэмжлэлийн бүх шаардлага, эсхүл аль нэг буюу хэд хэдэн шаардлагатай холбогдуулан хэргийг эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргах;”



**4/32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсэг:**

“32.5.Өмгөөлөгчөөс өөр этгээдээр төлөөлүүлж байгаа иргэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцохгүй. Биечлэн оролцох тохиолдолд өөрийг нь төлөөлж байгаа этгээдээс татгалзсан тухайгаа шүүхэд бичгээр мэдэгдэнэ.”

**5/67 дугаар зүйлийн 67.1.4 дэх заалт:**

“67.1.4.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаарх мэдээллийг бүрэн өгч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд эвлэрэх, эвлэрүүлэн зуучлагчийн туслалцаа авах боломжтойг сануулах.”

**6/71 дүгээр зүйлийн 71.5 дахь хэсэг:**

“71.5.Шүүх иргэний хэрэг үүсгэнээс хойш явагдах эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хугацааг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 20.2-т заасныг харгалзан тогтооно.”

**7/74<sup>1</sup> дүгээр зүйл:**

**“74<sup>1</sup> дүгээр зүйл.Эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг баталгаажуулах ажиллагаа**

74<sup>1</sup>.1.Талууд эвлэрүүлэн зуучлуулах хүсэлт гаргасан, эсхүл шүүх эвлэрүүлэн зуучлалыг зохицтой гэж үзэж санал болгосныг зохигчид зөвшөөрсөн бол шүүгч нэхэмжлэлийг эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлж энэ тухай захирамж гаргана.

74<sup>1</sup>.2.Энэ хуулийн 74<sup>1</sup>.1-д заасны дагуу шилжүүлсэн нэхэмжлэлд тухайн шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулна.

74<sup>1</sup>.3.Талууд эвлэрлийн гэрээг бичгээр байгуулж гарын үсэг зурсны дараа эвлэрлийн гэрээг шүүгчид хүргүүлнэ.

74<sup>1</sup>.4.Эвлэрлийн гэрээ нь Иргэний хуульд нийцсэн, гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүй байна.

74<sup>1</sup>.5.Иргэний хэрэг үүсгэхээс өмнө шүүгч нэхэмжлэлийг эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлсний дагуу талууд эвлэрсэн бол шүүгч эвлэрлийн гэрээг баталгаажуулах захирамж гаргана.

74<sup>1</sup>.6.Иргэний хэрэг үүсгэнээс хойш шүүгч нэхэмжлэлийг эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлсний дагуу зохигчид эвлэрсэн бол шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлснийг сэргээж, эвлэрлийн гэрээг баталгаажуулж, хэргийг хэрэгсэхгүй болгох захирамж гаргана.

74<sup>1</sup>.7.Шүүгч эвлэрлийн гэрээг хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор хянаж баталгаажуулна. Талуудын байгуулсан эвлэрлийн гэрээ ойлгомжгүй, тодорхой бус болсон, эсхүл энэ хуулийн 74<sup>1</sup>.4-т заасныг зөрчсөн бол шүүгч эвлэрлийн гэрээг баталгаажуулахаас татгалзсан захирамж гаргана.

74<sup>1</sup>.8.Эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захирамж энэ хуулийн 75 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна. Энэ захирамжийг талууд сайн дураар биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийн нэг адил албадан гүйцэтгэнэ.

74<sup>1</sup>.9.Эвлэрүүлэн зуучлах журмаар эвлэрсэн бол талууд, зохигч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй.

74<sup>1</sup>.10.Иргэний хэрэг үүсгэнээс хойш нэхэмжлэлийг эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлсэн боловч эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтад хүрээгүй бол эвлэрүүлэн зуучлагч нэхэмжлэлийг шүүхэд шилжүүлнэ. Шүүгч нэхэмжлэлийг хүлээн авч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлснийг сэргээж, хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.

74<sup>1</sup>.11.Энэ хуулийн 74<sup>1</sup>.7-д заасан үндэслэлээр татгалзсан захирамж гаргасан нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дахин явуулахад саад болохгүй.

74<sup>1</sup>.12.Талууд хамтдаа, эсхүл аль нэг нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид хандсан тохиолдолд энэ хуулийн 74<sup>1</sup>.6, 74<sup>1</sup>.10-т зааснаас бусад заалт нэг адил хамаарна.

#### **8/80 дугаар зүйлийн 80.1.9 дэх заалт:**

“80.1.9.эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдах болсон бол.”

#### **9/80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсэг:**

“80.4.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн шалтгаан шүүгчийн заасан хугацаанд арилаагүй бол шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээж, хэргийг хэрэгсэхгүй болгох захирамж



гаргах бөгөөд захирамжид хэргийг шийдвэрлэхэд саад болж байгаа нөхцөл, түүнийг хэрхэн засах талаар тусгана.”

**10/91 дүгээр зүйлийн 91.1.4 дэх заалт:**

“91.1.4. ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон бол.”

**11/119 дүгээр зүйлийн 119.7, 119.8 дахь хэсэг:**

“119.7. Энэ хуулийн 119.4-т заасны дагуу шийдвэрийг гардан аваагүй нь гомдол гаргах хугацааг хуульд заасан журмын дагуу тоолоход саад болохгүй.

119.8. Шүүхийн буруутай үйл ажиллагааны улмаас энэ хуулийн 119.4-т заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд энэ хуулийн 119.7 дахь хэсгийн заалт хамаарахгүй. Энэ тохиолдолд шийдвэрийг энэ хуулийн 119.5-д заасан журмын дагуу хүргүүлж, хугацааг энэ хуулийн 119.6-д заасны дагуу тоолно.”

**12/125 дугаар зүйлийн 125.2, 125.3 дахь хэсэг:**

“125.2. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан үндэслэлээр эвлэрүүлэн зуучлал дуусгавар болж, шүүхэд нэхэмжлэл гаргасан бол энэ хуульд заасны дагуу шүүх ердийн журмаар шийдвэрлэнэ.

125.3. Энэ хуулийн 125.2-т заасан үндэслэлээр хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх явцад эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дахин явуулж болно.”

**13/172 дугаар зүйлийн 172.4 дэх хэсэг:**

“172.4. Хяналтын журмаар гомдол гаргасны дараа зохигч эвлэрсэн, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэгчийн шаардлагыг зөвшөөрсэн бол анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгоно. Энэ тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгохгүй.”

**14/176 дугаар зүйлийн 176.4 дэх хэсэг:**

“176.4. Хяналтын шатны шүүхийн тогтоолд үг, үсэг, тооны зэрэг техникийн шинжтэй алдаа гарсан бол танхимын шүүх бүрэлдэхүүн хуралдаж, залруулга хийж болно.”



**2 дугаар зүйл.** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт “Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг үндэслэн тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгч, танхимын тэргүүн хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг захирамж гарган томилно.” гэсэн хоёр дахь өгүүлбэр, 25 дугаар зүйлийн 25.2.6 дахь заалтын “шийдвэрийт” гэсний дараа “гардаж авах,” гэж, 43 дугаар зүйлийн 43.8.1 дэх заалтын “болсон” гэсний дараа “эвлэрүүлэн зуучлагч,” гэж, 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсгийн “эвлэрлийн гэрээ” гэсний дараа “, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсан бол түүний үр дүн” гэж, 86 дугаар зүйлийн 86.1 дэх хэсгийн “шүүх хуралдаанд” гэсний дараа “гурав хүртэл” гэж, 91 дүгээр зүйлийн 91.1.1 дэх заалтын “өмгөөлөгч,” гэсний дараа “эвлэрүүлэн зуучлагч,” гэж, 106 дугаар зүйлийн 106.2 дахь хэсэгт “Зохигчид эвлэрэх хүсэлтэй байгаа тохиолдолд эвлэрүүлэн зуучлагчийн туслалцаа авах эсэхийг асууна.” гэсэн хоёр дахь өгүүлбэр, 117 дугаар зүйлийн 117.1 дэх хэсгийн “хуулийн” гэсний дараа “65.1.9-д заасан үндэслэл иргэний хэрэг үүсгэснээс хойш,” гэж, 132 дугаар зүйлийн 132.2 дахь хэсэгт “Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журмын дагуу явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон байх нь шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш гэр бүлийн маргааны талаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаанаас татгалзах үндэслэл болохгүй.” гэсэн хоёр дахь өгүүлбэр, 183 дугаар зүйлийн 183.1 дэх хэсгийн “тушаал,” гэсний дараа “эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захирамж,” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/129 дүгээр зүйлийн 129.1.7 дахь заалт:**

“129.1.7.зохигчид эвлэрүүлэн зуучлалын журмаар эвлэрэх хугацаа заах.”

**2/161 дүгээр зүйлийн 161.3 дахь хэсэг:**

“161.3.Давж заалдах журмаар хянан шийдвэрлээгүй хэргийг хяналтын шатны шүүх хэлэлцэхгүй.”

**4 дүгээр зүйл.** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийн “заалт” гэснийг “зүйл” гэж, 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсгийн “Шүүхийн тухай хуулийн 15.6.2, 16.3.2-т”, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “Шүүхийн тухай хуулийн 36.1.4, 37.1.6-д” гэснийг “Монгол Улсын шүүхийн тухай хуульд” гэж, 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийн “Өмгөөллийн тухай хуульд”<sup>1</sup> гэснийг “хуульд” гэж, 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийн “шүүгч, шүүх хуралдааны



нарийн бичгийн дарга” гэснийг “захиргааны ажилтан” гэж, 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсгийн “шүүх хуралдааны ажиллагааг тэмдэглэл үйлдэж баталгаажуулах,” гэснийг “шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх, шүүх хуралдааны явцыг дуу болон дурс бичлэгээр баталгаажуулах,” гэж, 119 дүгээр зүйлийн 119.4 дэх хэсгийн “зохигч” гэснийг “тал” гэж, 133 дугаар зүйлийн 133.1.8 дахь заалтын “хэргийн” гэснийг “иргэний хэргийн” гэж, 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалтын дугаарыг “25.1.8.” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсгийн “, эсхүл энэ хуулийн 119.4-т заасны дагуу хүрэлцэн ирж шүүхийн шийдвэрийг аваагүй” гэснийг, 163 дугаар зүйлийн 163.3 дахь хэсгийн “хариуцагч, гуравдагч этгээдээс” гэснийг, 188 дугаар зүйлийн 188.1 дэх хэсгийн “шийдвэр гаргасан” гэснийг, 188.2 дахь хэсгийн “хэргийг хянан шийдвэрлэсэн” гэснийг тус тус хассугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

### **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 04 дүгээр  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

#### **ЗАХИРГДАНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/52 дугаар зүйлийн 52.9 дэх хэсэг:**

“52.9. Тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээдээс нөлөөлөхөөр оролдсон тохиолдолд нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.”

**2/64 дүгээр зүйлийн 64.1.5 дахь заалт:**

“64.1.5. ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон бол.”

**3/81 дүгээр зүйлийн 81.9 дэх хэсэг:**

“81.9.Давж заалдах журмаар хянан шийдвэрлээгүй хэргийг хяналтын шатны шүүх хэлэлцэхгүй.”

**2 дугаар зүйл.**Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Үндсэн хууль<sup>1</sup>,” гэсний дараа “Монгол Улсын”, мөн хэсгийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай<sup>3</sup>,” гэсний дараа “Шүүхийн захиргааны тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль” гэж, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсгийн “шүүх” гэсний дараа “Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31.5-д, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9.2.6-д заасны дагуу” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“52.1.2.аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон түүний Тэргүүлэгчдийн гаргасан захиргааны акттай холбоотой;”

**4 дүгээр зүйл.**Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “оршин байгаа газрын” гэснийг “харьяалах” гэж, 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын тэргүүн” гэснийг “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч” гэж, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсгийн “Өмгөөллийн тухай<sup>8</sup> хуулийн 12” гэснийг “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 38” гэж, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсгийн “78 дугаар зүйлд” гэснийг “5.4-т” гэж, 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн “Шүүхийн тухай” гэснийг “Монгол Улсын шүүхийн тухай хууль болон бусад” гэж, 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийн “хуралдааны ажиллагааг тэмдэглэл үйлдэн” гэснийг “шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх, шүүх хуралдааны явцыг дуу болон дүрс бичлэгээр” гэж, 73 дугаар зүйлийн 73.4 дэх хэсгийн “авна” гэснийг “авах бөгөөд ийнхүү аваагүй нь хуульд заасан журмын дагуу гомдол гаргах хугацааг тоолоход саад болохгүй.” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1.3 дахь заалтын “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176.2.1-176.2.3-т заасан” гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 04 дүгээр  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтын “шүүх хуралдаан” гэсний өмнө “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 05 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар  
хот

#### Хуулийн төслийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2013 оны 6 дугаар сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлах саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 05 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар  
хот

#### Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай

Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх арга хэмжээний чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2.“Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх арга хэмжээний чиглэл”-д заасан арга хэмжээг Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус үүрэг болгосугай.

3.“Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх арга хэмжээний чиглэл”-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан ажиллах, холбогдох хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг 2014 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо /Б.Гарамгайбаатар/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

Монгол Улсын Их Хурлын 2014 оны  
34 дүгээр тогтоолын хавсралт

**ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХЖЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧИГЛЭЛ**

Дэс дугаар	Арга хэмжээ	Хариуцах байгууллага
<b>Нэг.Гадаад валютын урсгалыг сайжруулах, санхүү, эдийн засгийн эрсдэлээс сэргийлэх хүрээнд</b>		
1.1	<p>Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дараах чиглэлээр боловсруулж, өргөн мэдүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> <li>• төсвийн урсгал зардлын 20 хувиар бууруулж, хэмнэлтийн горимд шилжих;</li> <li>• улсын төсөвт ашиглах төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг тогтсон аргачлал, эх сурвалжид үндэслэн тооцох;</li> <li>• хөрөнгө оруулалтын зардлыг эрэмбэлэх замаар зохистой тувшинд болгох</li> <li>• Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх;</li> <li>• төрийн байгууллагудын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, тогтолцоог боловсронгуй болгох;</li> </ul>	Засгийн газар



	<ul style="list-style-type: none"><li>• төрийн байгууллагын тайлан, үйл ажиллагаанаас бусад асуудлаар төсвийн хөрөнгөөр хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийх, “хаалтын гэрээ” байгуулахыг хориглох</li></ul>	
1.2	<p>Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого баталсантай холбогдуулан Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах болон ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагааг сэргээхтэй холбогдох хуулийн төслийг дараах чиглэлээр боловсруулж, өргөн мэдүүлэх:</p> <ul style="list-style-type: none"><li>• уул уурхайн салбарын эрх зүйн орчныг тогтвортой болгох;</li><li>• хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд төр оролцохыг зохицой түвшинд байлгах;</li><li>• Эрдэс баялгийн бодлогын зөвлөлийг байгуулах;</li><li>• ашигт малтмалын хайгуулын ажлыг сэргээх</li></ul>	Засгийн газар
1.3	Оюу толгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалтыг түргэтгэх, уг төслийн хэрэгжилтэд Засгийн газраас бодлогын дэмжлэгт үзүүлж ажиллах	Засгийн газар
1.4	Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Таван толгойн ордын талаар Улсын Их Хурлаас баталсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах хүрээнд Таван толгойн орд газраас олборлож байгаа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулан, нэмүү өртөг шингээж, экспортын нэг цонхны бодлогын хүрээнд олон улсын зах зээлд борлуулах, уг зорилгоор орд газрыг иж бүрэн хөгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн асуудлыг эдийн засгийн үр ашигтай, улсын төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй байх хувилбараар, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог хангах зарчмаар цогцоор нь шийдвэрлэх	Засгийн газар
1.5	Экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах хүрээнд төмөр замын цариг, тээврийн бусад дэд бүтцийг шийдвэрлэх	Засгийн газар
1.6	Таван толгой-Гашуунсухайт, Нарийнсухайт-Шивээхүрэнгийн төмөр зам болон тээврийн бусад дэд бүтцийг төр, хувийн хөвшлийн түншлэлийн зарчмаар барьж байгуулах	Засгийн газар

1.7	Гадаад, дотоодын аялал жуулчлалыг дэмжих, аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулж, иргэний агаарын тээврийг дэмжих зэргээр аялал жуулчлалын хатуу болон зөвлөн дэд бүтцийг сайжруулах, тус салбарын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор бусад улсын чөлөөт бус, амралт зугаалга, бизнес төв, татваргүй худалдааны үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	Засгийн газар
1.8	Гадаадын хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгч, жуулчдад визийн дэглэмийг тааламжтай болгох	Засгийн газар
1.9	Хөрөнгө оруулалтын сангуйдыг бий болгох, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн хэрэгжилтийг идэвхжүүлэх	Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо
1.10	Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан “Гол нэрийн баараа бүтээгдэхүүний үнийг тогтвортжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт иж бүрэн дун шинжилгээ хийж 2014 оны 6 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд танилцуулан, цаашид уг хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлүүлэх	Засгийн газар Монголбанк
<b>Хоёр.Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийг дэмжих хүрээнд</b>		
2.1	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын татварын ачааллыг бууруулж, тайлагнах журмыг хөнгөвлөх, ил тод, нээлттэй болгох, зарим татварын хөнгөлөлт үзүүлэх чиглэлээр татварын холбогдох хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	Засгийн газар
2.2	Бизнесийн байгууллагын ўйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, далд эдийн засгийг бууруулах, татварын бааз, суурийг өргөтгөх чиглэлээр Эдийн засгийн өршөөлийн тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	Засгийн газар
2.3	Өмчлөх эрхийн тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	Засгийн газар
2.4	Төрийн байгууллагын хүнд суртлыг багасгах, тусгай зөвшөөрлийн тоог эрс цөөлөх чиглэлээр Аж ахуйн ўйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж, өргөн мэдүүлэх	Засгийн газар



2.5	Төсвийн ил тод байдлыг хангах, төсвийн гүйцэтгэлд татвар төлөгч, төрийн бус байгууллагаас хяналт тавын нэхцэлийг бүрдүүлэх	Засгийн газар
2.6	Үндэсний үйлдвэр, дотоодын аж ахуйн нэгжийн тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор бизнесийн үйл ажиллагааны өртөг, зардлыг нэмэгдүүлж байгаа хүчин зүйлсийн нөлөөллийг саармагжуулах, зээл, зээлийн даатгалд хамруулах болон гадаад, дотоодын үнэт цаасны зах зээлд оролцоход нь дэмжлэг үзүүлэх	Засгийн газар, Монголбанк
2.7	Хувийн хэвшилийн үйл ажиллагаанд давхацсан хяналт шалгалтыг хийхгүй байх	Засгийн газар
2.8	Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	Засгийн газар Монголбанк
<b>Гурав.Хөгжлийн бодлого, хөгжлийн зээл, санхүүжилтийн хүрээнд</b>		
3.1	Олон улсын зах зээлд арилжаалсан Засгийн газрын үнэт цаасны хөрөнгийн зарцуулалтын ил тод байдлыг хангах, хяналтыг сайжруулах, хөгжлийн зээл, санхүүжилт, улсын өрийн зохистой удирдлагын хүрээнд, олон улсын жишигт нийцүүлэн Өрийн удирдлагын тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	Засгийн газар
3.2	Бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангах хүрээнд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	Засгийн газар
3.3	Хөгжлийн банкны үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлж, засаглалыг сайжруулах, бие даасан байдлыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг зохистой болгох чиглэлээр Хөгжлийн банкны тухай хууль болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийд боловсруулж, өргөн мэдүүлэх	Засгийн газар
3.4	Хөрш оруутдай харилцан ашигтай хамтын ажиллагааг шинэ түвшинд хургэх нэхцэлийг бүрдүүлэх зорилгоор ОХУ, БНХАУ-ыг холбосон төмөр зам, хурдны авто зам, нефть, байгалийн хий, эрчим хүчиний дэд бүтэц бий болгох чиглэлээр хэлэлцээг идэвхжүүлэх	Засгийн газар
<b>Дөрөв.Төрийн өмчийн удирдлагын тогтолцоог шинэчлэх хүрээнд</b>		
4.1	Төрийн өмчийн хороо болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагын тогтолцоог шинэчлэх, засаглалын бие даасан байдлыг хангах, үйл ажиллагааг бизнесийн зарчимд бүрэн нийцүүлэх, Засгийн газраас төрийн өмчит компанийтай зөвхөн татвар ногдуулах, ногдол ашиг хуваарилах байдлаар харилцдаг болох чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	Засгийн газар



4.2	Монгол Улсын Их Хурлын 2010 оны 72 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд тулш, эрчим хүчиний үнэ тарифыг чөлөөлж, тус салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, эрчим хүчиний шинэ эх үүсвэр болон дамжуулах шугамыг төр, хувийн хэвшлийн туншлэлийн зарчмаар барьж байгуулах асуудлыг шуурхай шийдвэрлэх	Засгийн газар, Эрчим хүчиний зохицуулах хороо
4.3	Төрийн өмчийн томоохон аж ахуйн нэгжийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 2014-2016 онд хувьчлах, тэдгээрийн удирдлагыг төр, хувийн хэвшлийн туншлэлийн зарчимд шилжүүлэх хөтөлбөрийг боловсруулж, өргөн мэдуулэх	Засгийн газар
4.4	Уламжлалт бус газрын тос, нүүрс шингэрүүлэх, хийжкуулэх, эрчим хүч экспортлох төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд бодлогын дэмжлэг үзүүлэх	Засгийн газар

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2014 оны 05 дугаар  
сарын 02-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар  
хот

### Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг сахин хамгаалах үйлсэд хүчин зүтгэсэн цэргийн бэлтгэл албаны дээд офицерүү нийгмийн хамгааллыг сайжруулах ЗОРИЛГООР,

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, гучин дерөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Нэг. Цэргийн алба хаасны тэтгэвэр авах эрх бүхий Монгол Улсын генерал цолтой цэргийн бэлтгэл албаны дээд офицерт цэргийн цолны цалинг цолны зэрэглэлээс хамааран 36-40 хүртэлх хувь хэмжээгээр тооцож сар бүр олгохоор холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулахыг Засгийн газар /Н.Алтанхуяг/-т чиглэл болгосугай.

Хоёр. Холбогдох зардлыг жил бүр төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т чиглэл болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 3 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 71

Улаанбаатар  
хот

### Журам, чиглэл шинэчлэн батлах тухай

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8.1, 8.2, 8.4, 8.7, Боловсролын тухай хуулийн 39.7 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ыг 1 дүгээр, “Тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэл”-ийг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”-д дараах өөрчлөлтийг оруулсугай:

2.1. журмын 2.3 дахь хэсгийг “Сургалтын зээл нь сургалтын төлбөр байна.” гэж өөрчлөх;

2.2. журмын 2.6 дахь хэсгийн “..., амьжиргааны зардлыг суралцагчийн дансанд тус тус” гэснийг хасах.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолын 3, 5 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолыг 2014-2015 оны хичээлийн жилийн эхнээс эхлэн мөрдөж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантомөрт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД

Л.ГАНТӨМӨР



Засгийн газрын 2014 оны 71 дүгээр  
тогооолын 1 дүгээр хавсралт

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД  
СУРАЛЦАГЧИД СУРАЛЦАГЧИЙН ТЭТГЭЛЭГ  
ОЛГОХ ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

1.1. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.6-д заасны дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагын диплом, бакалавр, магистр, докторын боловсрол эзэмших өдрийн ангид болон хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад амьжиргааны тэтгэлэггүй суралцаж байгаа Монгол Улсын иргэн, хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэнд тус тус сургалтын төлбөр, суралцагчийн тэтгэлэг, санхүүгийн дэмжлэгийг (цаашид “тэтгэлэг” гэх) олгоход энэхүү журмыг дагаж мөрднө.

2. Үндэсний тэтгэлэг

2.1. Суралцагчид тэтгэлэг олгох дээд боловсролын сургалтын байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар аттестатчилагдсан байх;

2.1.2. нийт төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг төгссөнөөс хойш хагас жил, жилээр гаргаж хэвшсэн байх;

2.1.3. төгсөгчдийн судалгаагаар тэтгэлэг олгогдохоос 2 жилийн өмнөх төгсөгчдийн 30 хувь нь мэргэжлээрээ ажлын байраар хангагдсан байх;

2.1.4. оюутны үйлчилгээ, төгсөгчидтэй ажиллах бүтэцтэй байх;

2.1.5. удирдлагын мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлсэн байх;

2.1.6. сургуулийн нэрэмжит тэтгэлэг олгодог байх.



2.2. Дараах шаардлагыг хангасан диплом, бакалаврын хөтөлбөрийн суралцагчид үндэсний тэтгэлэг олгоно:

2.2.1. элсэлтийн журмын шаардлагыг ханган элссэн өдрийн ангийн суралцагч байх;

2.2.2. хичээлийн жилийн нэг улиралд 12-оос доошгүй багц цагийн хичээл судалж, дүгнүүлсэн байх.

2.3. Дараах шаардлагыг хангасан магистр, докторын хөтөлбөрт суралцагчид үндэсний тэтгэлэг олгоно:

2.3.1. магистрын хөтөлбөрт шинээр элсэгчийн бакалаврын дипломын голч дүн нь 2.8-аас доошгүй байх;

2.3.2. докторын хөтөлбөрт шинээр элсэгчийн магистрын дипломын голч дүн нь 3.0-аас доошгүй байх;

2.3.3. хичээлийн жилийн нэг улиралд 10-аас доошгүй багц цагийн хичээл судалж, дүгнүүлсэн байх.

2.4. Үндэсний тэтгэлгийг нэг хичээлийн жилд 10 хүртэлх сарын турш олгоно. Тэтгэлэг олгох нийт хугацаа нь тухайн мэргэжлийн сургалтын хөтөлбөрт заасан жилээс хэтрэхгүй байна.

### 3. Урамшууллын тэтгэлэг

3.1. Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад сурлагын өндөр амжилт гарган суралцаж байгаа болон тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэлээр өдрийн ангид амжилттай суралцаж байгаа суралцагчид урамшууллын тэтгэлэг олгоно.

3.2. Тусгай шаардлага хангасан суралцагчид урамшууллын тэтгэлгийг үндэсний тэтгэлгийн хэмжээнээс хувиар тооцон нэмж олгоно.

3.3. Тухайн улирлын урамшууллын тэтгэлгийг өмнөх улирлын голч дүнг харгалзан олгоно.

3.4. Дараах тусгай шаардлагыг хангасан диплом, бакалаврын хөтөлбөрт суралцагчид урамшууллын тэтгэлэг олгоно:

3.4.1. энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэлээр элсэлтийн ерөнхий

шалгалтын дундаж нь 720-иос дээш оноотой шинээр элсэгчид, 3.4 болон түүнээс дээш голч дүнтэй суралцагчид 50 хувийн;

3.4.2. 3.8 болон түүнээс дээш голч дүнтэй суралцаж байгаа суралцагчид 75 хувийн;

3.4.3. боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр зохион байгуулсан улсын олимпиадад эхний гурван байрт шалгарсан, олон улсын олимпиадад шагналт байр эзэлсэн шинээр элсэгчид эхний хичээлийн жилд 100 хувийн.

3.5. Дараах тусгай шаардлагыг хангасан магистр, докторын хөтөлбөрт суралцагчид урамшууллын тэтгэлэг олгоно:

3.5.1. 3.6-аас дээш голч дүнтэй суралцсан өдрийн ангийн магистрант, докторантад 75 хувийн;

3.5.2. хөндлөнгийн хянан магадлагаа бүхий олон улсын мэргэжлийн сэтгүүлд нэгээс доошгүй өгүүлэл хэвлүүлсэн магистрант, докторантад 100 хувийн;

3.6. Урамшууллын тэтгэлгийг давхардуулан олгохгүй.

4. Сургалтын төлбөр болон амьжиргааны зардал

4.1. Дараах суралцагчид сургалтын төлбөр олгоно:

4.1.1. бүтэн өнчин суралцагч;

4.1.2.хөгжлийн бэрхшээлтэй эсхүл эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын хөтөлбөрт суралцагч;

4.1.3. хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн бакалаврын хөтөлбөрийн нэг суралцагч;

4.1.4.хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэн;

4.1.5 багш бэлтгэдэг төрийн өмчийн их, дээд сургуульд багш мэргэжлээр элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтад 650-750 оноо авсан бол сургалтын төлбөрийг 70 хувь, 751-ээс дээш оноо авсан бол сургалтын төлбөрийг 100 хувь.



4.2. Дараах суралцагчид амьжиргааны зардал олгоно:

4.2.1. хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад амьжиргааны тэтгэлэггүй суралцаж байгаа Монгол Улсын иргэн;

4.2.2. хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэн;

4.2.3. багш бэлтгэдэг төрийн өмчийн их, дээд сургуульд амжилттай суралцаж байгаа хөдөө, орон нутагт багшлах дадлага гүйцэтгэх суралцагчид тухайн сургуулийн нэг хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 30 хувьтай тэнцэх хэмжээний амьжиргааны зардал.

4.3. Сургалтын төлбөр, амьжиргааны зардлын хэмжээг Боловсролын болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

4.4. Сургалтын төрийн сан нь сургалтын төлбөр болон амьжиргааны зардал авах суралцагчтай гэрээ байгуулна. Энэхүү гэрээний загварыг Боловсролын болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

5. Бүрдүүлэх бичиг баримт

5.1. Тэтгэлэгт хамрагдах суралцагч нь дараах баримт бичгийг бүрдүүлэн суралцаж байгаа дээд боловсролын сургалтын байгууллагад өгнө:

5.1.1. элсэлтийн ерөнхий шалгалтын батламж (шинээр элсэгч);

5.1.2. боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас олгосон суралцах эрхийн бичиг;

5.1.3. энэхүү журмын 4.1 дэх хэсэгт заасан суралцагчийн хувьд эрх бүхий этгээдийн баталгаажуулсан холбогдох баримт бичиг, тодорхойлолт;

5.1.4. энэхүү журмын 4.2.1, 4.2.2. дахь хэсэгт заасан суралцагчийн хувьд боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр.

## 6. Санхүүжилт

6.1. Дээд боловсролын сургалтын байгууллага нь үндэсний болон урамшууллын тэтгэлэг авах шаардлага хангасан суралцагчийн голч дүн, баримт бичгийг хянаж, тухайн сургуулийн оюутны байгууллагатай зөвшилцэн, тэтгэлэг олгох тухай хүсэлтээ улирал бүр Сургалтын төрийн санд хүргүүлнэ.

6.2. Сургалтын төрийн сан нь дээд боловсролын сургалтын байгууллагаас ирүүлсэн тэтгэлэг олгох тухай мэдээллийг хянан магадласны үндсэн дээр үндэсний болон урамшууллын тэтгэлгийг сар бүр тооцож, улирал тутам суралцагчийн дансанд шилжүүлнэ.

6.3. Үндэсний болон урамшууллын тэтгэлэг авсан суралцагч чөлөө авсан эсхүүл энэхүү журамд заасан голч дүнгийн шаардлагыг хангаагүй тохиолдолд санхүүжилтийг зогсоон.

6.4. Сурлагын голч дүнгийн шаардлага хангаагүйгээс үндэсний болон урамшууллын тэтгэлгийг нь зогсоосон суралцагч дараагийн улиралд голч дүнгийн шаардлага хангавал тэтгэлгийг үргэлжлүүлэн олгоно.

6.5. Энэхүү журмын 4.2.1 дэх хэсэгт заасан суралцагчийн амьжиргааны зардлыг Монгол Улсаас тухайн оронд суугаа дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан олгоно. Дипломат төлөөлөгчийн газар нь өөрийн суугаа болон хавсрсан суугаа оронд суралцах байгаа Монгол Улсын иргэний сурлагын дүнгийн талаархи мэдээллийг жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор Гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан Сургалтын төрийн санд хүргүүлнэ.

6.6. Энэхүү журмын 4.1.4, 4.2.2 дахь хэсэгт заасан суралцагчид сургалтын төлбөр, амьжиргааны зардлыг тухайн хэлэлцээрт заасан нөхцөлийн дагуу олгоно:

6.6.1. суралцагчид олгох тэтгэлгийн хэмжээг холбогдох хэлэлцээрт тодорхой заагаагүй бол боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан шийдвэрээр тогтооно;

6.6.2. дээд боловсролын сургалтын байгууллага нь тухайн суралцагчийн голч дүн, хичээлийн ирц, дотоод дүрэм журмын шаардлагыг хангасан тухай мэдээллийг хичээлийн жилийн улирал бүр Сургалтын төрийн санд хүргүүлнэ;



6.6.3. Сургалтын төрийн сан нь дээд боловсролын сургалтын байгууллагаас ирүүлсэн суралцагчийн мэдээллийг хянан магадласны үндсэн дээр сургалтын төлбөр, амьжиргааны зардлыг суралцаж байгаа сургалтын байгууллагад нь шилжүүлнэ.

## 7. Бусад

7.1. Сургалтын байгууллага нь суралцагчийн тэтгэлгийн асуудлаар хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, суралцагчийн мэдээллийг удаа дараа буруу гаргаж ирүүлсэн нь тогтоогдвол сургуулийн удирдлага, холбогдох албан тушаалтанд хуульд заасны дагуу хариуцлага тооцно.

7.2. Энэхүү журам нь хоёр дахь удаагаа бакалавр, магистр, докторын хөтөлбөрт хамрагдаж байгаа суралцагчид хамаарахгүй.

7.3. Сургалтын төлбөр болон амьжиргааны зардлыг санхүүжүүлэх гэрээ, санхүүжилттэй холбогдон гарсан маргааныг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмаар зохицуулна.

Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

## ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ

Сурах чиглэл		Хөтөлбэрийн нэр	Хөтөлбэрийн түвшин <sup>1</sup>		
Байгаль орчин, ногоон хөгжил	1	Байгалийн нехэн сэргээлт		MSc	
	2	Байгаль орчны нэлөөллийн үнэлгээ, менежмент	BSc	MSc	
	3	Уур амьсгалын өөрчлөлт		MSc	PhD
	4	Үсны нөөцийн үнэлгээ, менежмент	BSc	MSc	PhD
Боловсрол	5	Тусгай хэрэгцээт боловсрол		MSc	PhD
	6	Хүүхдийн хөгжил судлал	BSc	MSc	PhD
	7	Сургалтын технологи		MSc	PhD
	8	Сургуулийн өмнөх, бага боловсролын сургалтын арга зүй	BSc	MSc	PhD
Соёл	9	Соёлын өвийн сэргээн засварлагч		MEng	
	10	Сонгодог урлаг			
Эрүүл мэнд	11	Мэс засал	BSc	MSc	PhD
	12	Хүүхдийн анагаах		MSc	PhD
	13	Нийгмийн эрүүл мэнд		MSc	PhD
	14	Био анагаах		MSc	PhD
	15	Сувилахуй		MSc	PhD

Уул уурхай	16	Геологи уул уурхай, маркшайдер	BEng	MEng	
	17	Уул уурхайн ашиглалт, техник технологи	BEng	MEng	
	18	Ашигт малтмалын баяжуулалт	BEng	MEng	
	19	Газрын тосны хайгуул, боловсруулалт	BEng	MEng	
Хөдөө аж ахуй	20	Мал эмнэл зүй		MSc	PhD
	21	Тэжээл бэлчээр судлал	BSc	MSc	PhD
	22	Зоо инженер технологи		MEng	
	23	Газар тариалан		MSc	
Эрчим хүч, дэд бүтэц	24	Үс, дулааны хангамж, чанарын үнэлгээ	BEng	MEng	
	25	Сэргээгдэх эрчим хүч (салхи, үс, нар)	BEng	MEng	
	26	Цэвийн технологи	BEng	MEng	PhD
Зам тээвэр	27	Хүнд машин механизм	BEng	MEng	
	28	Зам гүүрийн барилга, байгууламж	BEng	MEng	
	29	Иргэний нисэх	BEng	MEng	
Барилга хот байгуулалт	30	Барилгын материалын үйлдвэрлэл	BEng	MEng	
	31	Барилгын технологи, инженер	BEng	MEng	
	32	Хог хаягдлын боловсруулалт, менежмент		MEng	
	33	Архитектур, хот, бус нутгийн төлөвлөлт		MEng	PhD
Мэдээллийн технологи	34	Мэдээллийн технологи, аюулгүй байдал	BEng	MEng	PhD
	35	Сансрын технологи, ашиглалт		MEng	PhD
Суурь шинжлэх ухаан, тэргүүлэх технологи	36	Байгалийн ухаан	BSc	MSc	PhD
	37	Биологи, биотехнологи	BSc	MSc	PhD
	38	Нано технологи	BSc	MSc	PhD
	39	Материал судлал	BSc	MSc	
	40	Химийн инженерчлэл	BSc	MSc	PhD
Мэргэжлийн чиглэлийн тоо			24	39	20

<sup>1</sup>BSc-Бакалавр, BEng-Инженер бакалавр, MSc-Магистр, MEng-Инженер магистр, PhD-Доктор



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 3 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 72

Улаанбаатар  
хот

### Үндэсний хөтөлбөр батлах тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 18.1, Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”-ын 4.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

- “Монгол цуур” үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.
- “Монгол цуур” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалт, мэдээллээр хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэлд даалгасугай.
- “Монгол цуур” үндэсний хөтөлбөрийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Ц.ОЮУНГЭРЭЛ

Засгийн газрын 2014 оны 72 дугаар  
тогтоолын хавсралт

### “МОНГОЛ ЦУУР” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

#### 1. Нийтлэг үндэслэл

Монголын нүүдэлчдийн үндэсний сонгодог, уламжлалт соёлын биет бус өвийн ховор хосгүй төрөл, зүйл болох Монгол Алтайн Урианхайн цуур хөгжим, цуурдах урлаг нь үеэс үед өвлөгдөн уламжлагдсаар ирсэн боловч, өнөө цагт өвлөн уламжлагч эзэнтэйгээ хамт мартагдан алга болж, устах нэхцэл байдалд хүрээд байна.

Үүнтэй холбогдуулан Монгол Улс цуур хөгжмийн уламжлалт урлагийг яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн ЮНЕСКО-гийн жагсаалтад 2009 онд бүртгүүлсэн билээ.

Цуур хөгжмийн урлаг бол үе үеийн цуурчдын авьяас билэг, уран сэтгэмжээр бүтэж цогцолсон баялаг урын сан, цуурдах эрдэм, арга барил бүхий соёлын өвөрмөц, нандин өв юм. Цуурын олон зүйл аяз, татлагууд нь нот (эгшгийн бичээс)-оор биш зөвхөн тухайн авьяас билэгтний онцгой ой тогтоомж, сонсгол, мэдрэхүйгээр өнө эртнээс өнөөдрийг хүртэл үеэс үед уламжлагдаж ирсэн учраас өвлөн уламжлагч эзэнтэйгээ хамт алга болох эрсдэл ихтэй байна.

Баруун Монголын урианхайн цуурдах урлагийг өвлөн уламжлагч, сүүлчийн нээрт төлөөлөг Ховд аймгийн Дуут сумын ардын гоц авьяастан Паарайн Наранцогт агсны амьд сэргүүн ахуйдаа зааж сургасан түүний үр хүүхэд, ач, зээ нар, нутгийн зарим авьяастан зэрэг цөөн тооны хүмүүс л өнөө үед энэхүү ховор нандин урлагийг өвлөн аварч үлдэх итгэл найдвар болоод байна.

Алдарт цуурч П.Наранцогтын удмын цуурчид, монгол цуур хөгжмийн урлагийг судлаач эрдэмтэд санаачлан 2006 оноос “Хүннү цуурчдын холбоо” ТББ байгуулан ажиллаж байна. Тус холбооноос ирээдүйн цуурчдыг бэлтгэх анхан шатны сургалтыг Улаанбаатар хот, Орхон, Ховд, Баян-Өлгий аймгуудад зохион байгуулснаар цөөн тооны өсвөрийн цуурчдыг бэлтгээд байна. Гэвч багш, шавь нарын тоо цөөн, цуурдах арга барил, ур чадвар дутмаг, урын сан ядуу, төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг хомс байгаа нь цуур хөгжмийн гайхамшигт урлагийг хадгалж хамгаалан, өвлөн уламжлуулахад хүндрэл бэрхшээл учруулж байна.

Олон зууны тэртээгээс өвлөн уламжилж ирсэн цуурын урлаг, цуурдах эрдэм, уламжлалт урын сан, цуурын урлал, холбогдох зан үйлийг сэргээж, орчин цагийн сургалтын тогтолцоог төлөвшүүлэн залгамж чанараыг хадгалах нь ЮНЕСКО-гийн соёлын биет бус өвийг хамгаалах болон Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай Конвенциуд, “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”-ыг амьдралд хэрэгжүүлэх нэгэн чухал алхам болно.

2. Үндэсний хөтөлбөр боловсруулах эрх зүйн үндэслэл

2.1. ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай Конвенци (2003 он);



2.2. ЮНЕСКО-гийн Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай Конвенци (2005 он);

2.3. Монгол Улсын Соёлын тухай хууль (1996 он);

2.4. Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль (2001 он);

2.5. “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод сууринсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” (2008 он);

2.6. “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого” (2012 он).

### 3. Үндэсний хөтөлбөрийн зорилго

3.1. Монгол цуур хөгжмийн уламжлалт урлагийг устах аюулаас сэргийлж, хадгалж хамгаалах, хөгжүүлэх, хойч үедээ өвлүүлэх, сургах, судлах, сурталчлах үйл ажиллагааны тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчин бүрдүүлэх, цуур хөгжим, цуурдах урлагийн уламжлалыг сэргээж, түгээн дэлгэрүүлэхэд төрөөс санхүүгийн бодитой дэмжлэг үзүүлэхэд оршино.

### 4. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг соёлын салбарын хөгжлийн бодлого, холбогдох хууль тогтоомж, бусад хөтөлбөр, төсөлтэй уялдуулах;

4.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, хүртээмжтэй, төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, ардын авьяастан, судлаач, сонирхогч талын эрэлт хэрэгцээ, оролцоог хангасан байх.

### 5. Үндэсний хөтөлбөрийн зорилт

5.1. Монгол цуурыг хадгалж хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

5.2. Монгол цуурын судалгааг хөгжүүлэх;

5.3. Цуурын албан ба албан бус сургалтын үр ашигтай арга хэлбэрийг олж тогтоон, сургалтад хэрэглэх;

5.4. Цуур хөгжмийн урлагийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлахад чиглэсэн төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүмүүс, ардын авьяастны санал, санаачилгыг дэмжих;

5.5. Цуурын урлаг, цуурчдын төрөлжсөн бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх;

5.6. Цуурчдыг хөхиүлэн дэмжиж алдаршуулах.

**6. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа (он)	Хариуцах байгууллага	Санхүүжилт (сая төгрөгөөр)
6.1. Монгол цуурыг хадгалж хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлна.				
6.1.1.	Биет бус соёлын өвийг хадгалж хамгаалахтай холбогдсон дүрэм журам боловсруулж, батгуулах.	2014	-Соёл спорт, аялал жуулчлалын яам	-
		2015	-Соёлын өвийн төв	-
		2016		-
6.2. Монгол цуурын судалгааг хөгжүүлнэ.				
6.2.1.	-Цуур хөгжмийн уламжлалт урлагийн суурь судалгаа хийх; -Цуур хөгжмийн зэмсэг судлалын судалгаа; -Цуурдах арга барил, урын сангийн судалгаа; -Цуурын соёл, зан үйлийн судалгаа; -Цуурын танхимиийн болон шавь сургалтын судалгаа; -Цуурын өвлөн уламжлагчдын судалгаа; -Цуур болон цуур төст хөгжмийн харьцуулсан судалгаа.	2014	-Соёлын өвийн төв	8.0
		2015	-Соёл, урлаг судлалын хүрээлэн -“Хүннү цуурчдын холбоо” ТББ	10.0
		2016		10.0
6.2.2.	“Монгол цуурын өв уламжлалт” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал, дугуй ширээний цуврал ярилцлага зохион байгуулах.	2014	-Соёл, спорт, аялал жуулчлалын яам	2.0
		2015	-Соёлын өвийн төв -Соёл урлаг судлалын хүрээлэн	3.0
		2016	-“Хүннү цуурчдын холбоо”-ТББ	3.5
6.2.3.	Цуур хөгжмийн уламжлалт урлаг судлалын олон улсын симпозиум, фестиваль зохион байгуулах	2016	-Соёл, спорт, аялал жуулчлалын яам -Соёлын өвийн төв	50.0



6.2.4.	“Монгол цуур” судалгааны бүтээл хэвлүүлэх	2016	-Соёл, спорт, аялал жуулчлалын яам -Соёлын өвийн төв -Соёл урлагийн их сургууль	6.0
6.3.Албан ба албан бус сургалтын үр дунтэй арга хэлбэрээр цуурын сургалт явуулна.				
6.3.1	Цуурын сургаг багш, судлаачдыг бэлтгэх, цуурын танхимиин болон шавь сургалт явуулах арга хэмжээ зохион байгуулах	2014	-Соёл урлагийн их сургууль -Хөгжим бүжгийн коллеж	6.0
		2015	-Соёлын өвийн төв -“Хүннү цуурчдын холбоо”-ТББ	8.0
		2016	-Орон нутгийн театр, чуулга, соёлын төвүүд	8.0
6.3.2.	Соёлын өвийн төвийн дэргэд цуурын шавь сургалтын төв байгуулах	2016	-Соёл, спорт, аялал жуулчлалын яам -Соёлын өвийн төв	6.0
6.3.3	Цуурын сургалтын хөтөлбөр боловсруулах	2014	-Боловсрол, шинжлэх ухааны яам -Соёлын өвийн төв -Соёл урлагийн их сургууль -Хөгжим бүжгийн коллеж -“Хүннү цуурчдын холбоо”-ТББ	2.0
6.4. Цуур хөгжмийн урлагийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлаад чиглэсэн төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүмүүс, ардын авьяастны санал, санаачилгыг дэмжинэ.				
6.4.1.	Улсын болон олон улсын хэмжээнд зохион байгуулдаг ардын уламжлалт урлагийн наадам, уралдаан, гадаад оронд зохион байгуулдаг монголын соёлын өдрүүдэд цуурчдын төлөөлөл, цуур хөгжмийн урлагийн төрөл, зүйлийг оролцуулж байх;	2014	-Соёл, спорт, аялал жуулчлалын яам -“Хүннү цуурчдын холбоо”-ТББ	5.0
		2015		5.0
		2016		5.0

6.4.2.	Цуур хөгжмийн сургалтад зориулж DVD, хавсралт бүхий гарын авлага хэвлэнэ. (аймаг, нийслэлийн номын сангууд, сум, дүүрэг, соёлын биет бус өвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад тараах)	2014	-Соёлын өвийн төв -Соёл урлагийн их сургууль -Хөгжим бүжгийн коллеж -“Хүннү цуурчдын холбоо”-ТББ	5.5
6.4.3.	“Монгол цуурын аялгуун дээжис” CD хэвлүүлж, номын сан, сум дүүрэг, сургуулиудад түгээнэ.	2015	-Соёлын өвийн төв -“Хүннү цуурчдын холбоо”-ТББ -Соёл, урлаг судалын хүрээлэн	4.5
6.4.4.	Цуур хөгжмийн уламжлал, түүнтэй холбогдол бүхий зан үйл, ёс заншлыг харуулсан 2 баримтат кино бүтээх, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах	2015	-Соёл, спорт, аялал жуулчлалын яам -ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс -Соёлын өвийн төв -Соёл урлагийн их сургууль -Хөгжим бүжгийн коллеж -“Хүннү цуурчдын холбоо”-ТББ	5.0
		2016	-Соёл, спорт, аялал жуулчлалын яам -Соёлын өвийн төв -Соёл урлаг судалын хүрээлэн	5.0
6.4.5.	“Монголын цуурчид” намтар судалын ном хэвлүүлнэ.	2015	-Соёлын өвийн төв	3.0
6.4.6.	Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр цуврал нэвтрүүлэг бэлтгэж, сурталчилгаа явуулна.	2014	-Соёл, спорт, аялал жуулчлалын яам -Соёлын өвийн төв -Соёл, урлаг судалын хүрээлэн	2.0
		2015	-Соёл, спорт, аялал жуулчлалын яам -Соёлын өвийн төв -Соёл, урлаг судалын хүрээлэн	2.0
		2016	-Соёл, спорт, аялал жуулчлалын яам -Соёлын өвийн төв -“Хүннү цуурчдын холбоо”-ТББ Ховд аймгийн ЗДТГ, ССАЖ-ын газар	2.0
6.4.7.	Урианхайн нэрт цуурч П.Наранцогтын нэрэмжит цуурчдын наадмыг баруун бусэд зохион байгуулна.	2015	-Соёл, спорт, аялал жуулчлалын яам -Соёлын өвийн төв -“Хүннү цуурчдын холбоо”-ТББ Ховд аймгийн ЗДТГ, ССАЖ-ын газар	14.0



6.5. Цуурын урлаг, цуурчдын төрөлжсөн бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлнэ.				
6.5.1.	Соёлын өвийн улсын бүртгэл- мэдээллийн санг жил бүр цуур хөгжмийн төрөл, зүйлээр баяжуулах	2014	-Соёлын өвийн төв	-
		2015		
		2016		
6.5.2.	Цуур урлал, үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагааг дэмжих	2015	-Соёл, спорт, аялал жуулчлалын яам -Соёлын өвийн төв	5.5
6.6. Цуурчдыг хөхиүүлэн дэмжиж алдаршуулна.				
6.6.1.	Цуур хөгжим, цуурдах урлагийг нийтэд түгзэн дэлгэрүүлж сурталчлахад үнэтэй хувь нэмэр оруулсан хувь хүн, байгууллагыг шагнаж урамшуулах	2014	-Соёл, спорт, аялал жуулчлалын яам	5.0
		2015		5.0
		2016		5.0
Нийт дүн				201.0

## 7. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

7.1. “Монгол цуур” хөтөлбөрийг 2014 - 2016 онд хэрэгжүүлнэ;

7.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт (санхүүжилтийг 2014, 2015, 2016 оны улсын төсөвт тусгана).

Хэрэгжүүлэх хугацаа (он)	Улсын төсвөөс гаргах хөрөнгө (сая төг)
2014	35.5
2015	65.0
2016	100.5
Дүн	201.0

8. Үндэсний хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын хүлээх үүрэг

8.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг улс орны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй нягт уялдуулах;

8.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд олон улсын байгууллага, хандивлагч орнуудтай хамтран ажиллах;

8.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцож байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, ардын авьяастны оролцоо, санаачилгыг дэмжих;

8.4. Цуур хөгжим, цуурдах урлагийг судалж сурталчлах, өвлөж уламжуулах, хадгалж хамгаалах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

8.5. Төв, орон нутгийн мэргэжлийн соёл, урлагийн байгууллага, цуурын урлагийг дэмжигч, сонирхогчдын нэгдэл, холбоо, авьяастнуудтай хамтран ажиллах, дэмжлэг туслалцаа үзүүлэх;

8.6. Цуурын урлагийг дэмжих чиглэлээр тодорхой үр дүнтэй ажилласан хамтлаг, нэгдэл, холбоо, авьяастнуудыг урамшуулан дэмжих;

8.7. Үндэсний хөтөлбөрийг олон нийтэд сурталчлан таниулж, хэрэгжилтэд нь хяналт тавих;

8.8. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэвлэл мэдээлэл, соёл, боловсрол, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах.

9. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага,  
зохион байгуулалт

9.1. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт эд соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж ажиллана.

9.2. Үндэсний хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг Соёлын өвийн төв зохицуулан зохион байгуулж, биелэлтийг жил бүр соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

9.3. Тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг аймаг, нийслэлийн Засаг дарга баталж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллана.

10. Үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:

10.1. Цуурын урлагийг өвлөн уламжилж хөгжүүлэх эрх зүйн орчин сайжирсан байна;

10.2. Монгол цуурын суурь болон хавсарга судалгаа бүрэн хийгдсэн байна;



10.3. Цуурч-ардын авьяастны тооны өсөлт;

10.4. Цуур хөгжим, цуурдах урлагийн талаар хэвлүүлсэн ном, хэрэглэгдэхүүн, баримтат киноны чанар, агуулга, хүртээмж, тоо ширхэг;

10.5. Цуурын урлагийн үзлэг, наадам, уралдаан, шавь болон танхимийн сургалт, сурталчилгаа, судалгааны нэр төрөл, тоо хэмжээ, чанар, төрийн бус байгууллага, иргэд, ардын авьяастны оролцооны өсөлт;

10.6. Цуурчдын талаархи бүртгэл мэдээллийн сангийн баяжилт.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 3 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 73

Улаанбаатар  
хот

### Тооны дээд хязгаар, мөнгөн төлбөрийн хэмжээ тогтоох тухай

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5, 8 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2009 оны 33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2014 онд цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн тооны дээд хязгаарыг хавсралт ёсоор баталсугай.
2. Цэргийн дүйцүүлэх албыг 2014 онд мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг 4.413.314 (дөрвөн сая дөрвөн зуун арван гурван мянга гурван зуун арван дөрвөн) төгрөг байхаар тогтоосугай.
3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэ, Сангийн сайд Ч.Улаан нарт, цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу хаалгах, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдийн мөнгөн төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД

Д.БАТ-ЭРДЭНЭ



Засгийн газрын 2014 оны 73 дугаар  
тогтоолын хавсралт

2014 ОНД ЦЭРГИЙН АЛБЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХААХ  
ИРГЭДИЙН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР

№	Аймаг, нийслэл	Тооны дээд хязгаар
1	Архангай	40
2	Баян-Өлгий	40
3	Баянхонгор	25
4	Булган	35
5	Говь-Алтай	30
6	Говьсүмбэр	5
7	Дархан-Уул	35
8	Дорнговь	10
9	Дорнод	30
10	Дундговь	25
11	Завхан	30
12	Орхон	15
13	Өвөрхангай	45
14	Өмнөговь	40
15	Төв	40
16	Увс	35
17	Сэлэнгэ	30
18	Ховд	60
19	Хөвсгөл	70
20	Хэнтий	20
21	Улаанбаатар	54
	БҮГД	714

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2014 оны 3 дугаар  
сарын 21-ний өдөр

Дугаар 86

Улаанбаатар  
хот

**Цагдаагийн алба хаагчид мөнгөн  
урамшил олгох журам батлах тухай**

Цагдаагийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Цагдаагийн алба хаагчид мөнгөн урамшил олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Цагдаагийн албан хаагчид олгох мөнгөн урамшлыг Монгол Улсын 2014 оны Төсвийн тухай хуулиар тухайн зардалд батлагдсан төсвийн хэмжээнд багтаан 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс



эхлэн энэ журмын дагуу олгохыг Цагдаагийн ерөнхий газар (Б.Билэгт)-т даалгасугай.

3. Мөнгөн урамшил олгоход шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Хууль зүйн сайд Х.Тэмүүжин, Сангийн сайд Ч.Улаанд тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

ХУУЛЬ ЗҮЙН САЙД

Х.ТЭМҮҮЖИН

Засгийн газрын 2014 оны 86 дугаар  
тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИД МӨНГӨН  
УРАМШИЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Цагдаагийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсэгт заасан мөнгөн урамшил (цаашид “мөнгөн урамшил” гэх) олгоход Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 11, 12 дугаар зүйл болон энэхүү журмыг баримтална.

2. Цагдаагийн алба хаагч аймгийн төвөөс бусад нэг буюу хэд хэдэн суманд тасралтгүй 60 сар ажилласан бол таван жил тутам нэг удаа мөнгөн урамшил авах эрхтэй.

3. Мөнгөн урамшил олгох хугацааг аймгийн төвөөс бусад суманд томилогдсон өдрөөс эхлэн тасралтгүй ажилласан 60 сарын хугацаагаар тооцно.

4. Цагдаагийн алба хаагчийн сүүлийн 60 сард хашиж байсан албан тушаалын цалингийн сүлжээгээр тогтоосон зэрэглэл, шатлалын цалингийн дунджийг 30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр мөнгөн урамшлыг тооцож олгоно.

5. Аймгийн төвөөс бусад сумд томилогдон тасралтгүй 60 сар ажилласан боловч 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө өөр албан тушаалд шилжсэн, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон эсхүл цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон боловч эргэн ажиллаж байгаа, албанаас чөлөөлгэдсэн, халагдсан цагдаагийн алба хаагчид энэ журамд заасан мөнгөн урамшлыг олгохгүй.

6.Цагдаагийн алба хаагч нь мөнгөн урамшил авах хүсэлтээ тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газрын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж буюу албан тушаалтанд бичгээр гаргана.

7.Энэ журмын 6 дугаар зүйлд заасан албан тушаалтан хүсэлтийг хүлээн авч, аймгийн төвөөс бусад сумд тасралтгүй ажилласан хугацааг тодорхойлно.

8.Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь аймгийн төвөөс бусад сумд ажиллаж байгаа энэ журамд заасан мөнгөн урамшил авах шаардлагыг хангасан цагдаагийн алба хаагчдын нэр, ажилласан хугацаа, тэдэнд олгох мөнгөн урамшилд шаардагдах хөрөнгийн судалгааг жил бүр гарган цагдаагийн төв байгууллагад хүргүүлнэ.

9.Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага энэ журмын 8 дугаар зүйлд заасан судалгааг хүргүүлэхдээ урамшил олгохыг хүссэн алба хаагчтай холбоотой дараах баримт бичгийг бүрдүүлж хавсаргана:

9.1.тухайн цагдаагийн алба хаагчийг томилсон шийдвэрийн хуулбар;

9.2.сүүлийн 60 сард хашиж байсан албан тушаалын үндсэн цалингийн тодорхойлолт;

9.3.ажиллаж байгаа цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

9.4.шаардлагатай тохиолдолд архивын лавлагаа.

10.Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга, санхүү, хүний нөөц хариуцсан ажилтнууд цагдаагийн алба хаагчийн ажилласан хугацаа, албан тушаалын сарын үндсэн цалинг үнэн зөв тодорхойлох үүрэгтэй.

11.Энэ журмын 8, 9 дүгээр зүйлд заасан судалгаа, баримт бичгийг Цагдаагийн төв байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж хүлээн авч, аймгийн төвөөс бусад сумд тасралтгүй ажилласан хугацааг тооцон мөнгөн урамшил олгох шийдвэр гаргуулах саналаа цагдаагийн төв байгууллагын даргад уламжлан шийдвэрлүүлнэ.

12.Мөнгөн урамшил олгох шийдвэр гарсан алба хаагчид урамшлыг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагаар дамжуулан олгоно.



13. Энэ журмын 8 дугаар зүйлд заасны дагуу ирүүлсэн судалгааг цагдаагийн төв байгууллагын санхүү, хүний нөөц хариуцсан нэгжүүд хүлээн авч мөнгөн урамшил олгох алба хаагчдын тоо, шаардагдах хөрөнгийг тооцон жил бүрийн төсөвтөө тусгана.

14. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь цагдаагийн төв байгууллагаас ирүүлсэн мөнгөн урамшил олгох алба хаагчдын тоо, түүнд шаардагдах хөрөнгийн тооцоого үндэслэн дараа жилийн улсын төсөвт тусгах ажлыг зохион байгуулна.

15. Албан тушаалтын сарын үндсэн цалин болон ажилласан хугацааг буруу тодорхойлох, хуурамч бичиг баримт бүрдүүлэх зэргээр мөнгөн урамшлыг буруу тогтоож олгосон албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 3 дугаар  
сарын 21-ний өдөр

Дугаар 92

Улаанбаатар  
хот

### Ардчилсан хувьсгалын 25 жилийн оий тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Ардчилал, хүний эрхийн өдөр”-2014 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Ардчилсан хувьсгалын 25 жилийн оий тэмдэглэсүгэй.

2. Ардчилсан хувьсгалын 25 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Ч.САЙХАНБИЛЭГ

Засгийн газрын 2014 оны 92 дугаар  
тогтоолын хавсралт

АРДЧИЛСАН ХУВЬСГАЛЫН 25 ЖИЛИЙН ОЙН АРГА  
ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮҮРЭГ БУХИЙ  
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Монгол Улсын Ерөнхий сайд
Гишүүд:	<ul style="list-style-type: none"><li>-Гадаад харилцааны сайд;</li><li>-Сангийн сайд;</li><li>-Боловсрол, шинжлэх ухааны сайд;</li><li>-Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд;</li><li>-Соёл, спорт, аялал жуулчлалын сайд;</li><li>-Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд;</li><li>-Эдийн засгийн хөгжлийн сайд;</li><li>-Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга (зөвшилцсөнөөр);</li><li>-Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр);</li><li>-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч.</li></ul>
Нарийн бичгийн дарга	-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2014 оны 3 дугаар  
сарын 21-ний өдөр

Дугаар 98

Улаанбаатар  
хот

**Журамд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай**

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 172 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлд дор дурдсан заалтыг нэмсүгэй:

“4.1.51. Худалдааны ажилчдын өдөр-жил бүрийн 12 дугаар сарын 3 дахь ням гараг”

2. Мөн журмын 4.1.8 дахь заалтыг “Хөнгөн, хүнсний аж үйлдвэрийн ажилтан, ажилчдын өдөр-жил бүрийн 3 дугаар сарын 26-ны өдөр” гэж өөрчлөн найруулсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

ЭДИЙН ЗАСГИЙН  
ХӨГЖЛИЙН САЙД

Н.БАТБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 3 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 103

Улаанбаатар  
хот

### Журамд нэмэлт оруулах тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Журам батлах тухай” Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлд дор дурдсан заалтыг нэмсүгэй:

“4.1.52. Ой модны салбарын ажилчдын өдөр-жил бүрийн 9 дүгээр сарын гурав дахь Ням гараг”

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН  
ХӨГЖЛИЙН САЙД

С.ОЮУН



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 3 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 108

Улаанбаатар  
хот

### Дотоодын цэргийн ангиудыг татан буулгах тухай

Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль, Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дотоодын цэргийн 05, 805 дугаар ангийг 2014 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөр тасалбар болгон татан буулгасугай.

2. Дотоодын цэргийн ангийн 05, 805 дугаар ангийн бие бүрэлдэхүүн, хугацаат цэргийн алба хаах үйл ажиллагаатай холбоотой төсөв, санхүү, дэд бүтэц, барилга байгууламж, материал техникийн хангамж, зэвсэг хэрэгслийг 2014 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс Цагдаагийн ерөнхий газрын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газарт шилжүүлэхийг Хууль зүйн сайд Х.Тэмүүжиннд даалгасугай.

3. Дотоодын цэргийн ангиуд татан буугдсантай холбогдуулан Дотоодын цэрэгт алба хааж байсан хугацаат цэргийн алба хаагчдыг Хил хамгаалах ерөнхий газарт шилжүүлэх, хугацаат цэргийн алба хаагчийн зардлыг ахлагч (харуулын цагдаа)-ийн зардалд шилжүүлэн зохицуулах арга хэмжээ авахыг Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэ, Хууль зүйн сайд Х.Тэмүүжин нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

ХУУЛЬ ЗҮЙН САЙД

Х.ТЭМҮҮЖИН

#### Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiin\_medeelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.5

Индекс: 14003